

**БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ ДЭХ ЦАГДААГИЙН НЭГДҮГЭЭР
ХЭЛТСИЙН 2018 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН
АЖЛЫН ТАЙЛАН**

2018 оны 12 дугаар сарын 10

Улаанбаатар хот

Тус хэлтэс нь 2018 онд хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас дэвшүүлсэн зорилт, хүрэх түвшингийн шалгуур үзүүлэлтийг хангах, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны стандартыг хэрэгжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох ажлын үр нөлөөг сайжруулах, алба хаагчдын шуурхай байдал, ажлын хариуцлага, сахилга бат, харилцааны соёлыг дээшлүүлэх, иргэдийн амгалан тайван ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, иргэдийг чирэгдүүлэхгүй түргэн шуурхай үйлчлэх, албаны бэлэн байдал, мэргэжлийн ур чадвараа сайжруулахад онцгой анхаарч Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль, тушаал, заавруудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан.

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын ажлын чиглэлээр
зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар**

1.1 Төлөвлөлт, зохион байгуулалтын чиглэлээр:

Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын их хурал, Засгийн газраас гаргасан Цагдаагийн байгууллагатай холбоотой үүрэг, даалгавар, шийдвэрүүдийг тасаг, хэсгийн дарга, ахлах нарт болон бие бүрэлдэхүүнд тухай бүрт нь хүргэж, шаардлагатай тохиолдолд үүрэг, даалгавар шийдвэрийн талаар сургалт зохион байгуулан Цагдаагийн байгууллагад холбогдох үндэсний хөтөлбөр, удирдах дээд байгууллагаас өгсөн үүрэг, даалгавар, шийдвэрүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнүүдийг гарган биелэлтийг тооцон Нийслэлийн цагдаагийн газрын холбогдох хэлтсүүдэд хүргүүлсэн. Удирдах дээд байгууллагаас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлийг бүртгэлжүүлэн тусдаа хавтас нээн биелэлтэд хяналт тавин хөтөлбөр, эрх зүйн актуудын биелэлтийг улирал, хагас, бүтэн жилээр тооцон Нийслэлийн цагдаагийн газарт хүргүүлсэн.

Хэлтсийн даргын зөвлөл 2018 онд 22 удаа хуралдаж, үйл ажиллагааны чиглэлээр 11, хүний нөөцийн чиглэлээр 182, алба хаагчдын сахилга хариуцлагын талаар 31, нийт 224 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийн дагуу албан тушаал дэвшүүлэх, өөрчлөх саналтай 28, тэтгэвэрт гаргаж, тэтгэмж олгуулах 4, цагдаагийн албанаас чөлөөлүүлэх 4 алба хаагчийн материалыг Нийслэлийн хүний нөөц сургалтын хэлтэст хүргүүлсэн. Офицер албан тушаал /ажлын байр/-ын сургалтад хамруулах 1, офицерын бүрэлдэхүүнд оруулах болон хугацааны цолоор болон Цагдаагийн ерөнхий газар, Нийслэлийн цагдаагийн газар бусад шагналаар шагнуулах 105 алба хаагчийн материалыг хүргүүлсэн байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Тэргүүн дэд дарга, Дэд дарга, Нийслэлийн цагдаагийн газрын дарга нарын өгсөн үүрэг, ажлын чиглэл, зөвлөмж, албан даалгаврын заалт бүрийн ард уг ажлыг хариуцан хэрэгжүүлэх албан тушаалтны нэр, цолыг бичиж, нэгдсэн байдлаар биелэлт үр дүнг нь тооцох албан тушаалтанд цохолт хийж эзэнжүүлэн, үр дүнг нь тооцож ажилласан. Тухайлбал: Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны 01 тоот албан даалгавар, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 01/591, Тэргүүн дэд даргын 2017 оны 5/27, 5/362, 5/393, 2018 оны 5/270, Нийслэлийн цагдаагийн газрын 2017 оны 14а/6077, 14а/6128, 14/6139 үүргийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргаж, биелэлтийг хүргүүлэн ажилласан.

Байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн 2013, 2014 оны байнга, түр, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, устгах хэргийн акт бүртгэлүүдийг Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх ББНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулж, Төв архиваас ирүүлсэн нөхөн бүрдүүлэлтийн хуваарийн дагуу шилжүүлсэн. Мөн 2016 оны

байнга, түр, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, устгах хэргийн акт бүртгэлийг баталгаажуулж, 2017 оны байнга, түр, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, устгах хэргийн акт бүртгэлийг баталгаажуулахаар 2018 оны 30и/2857 дугаартай албан бичгээр Төв архивт хүргүүлсэн. Төв архивт 1985-2013 он хүртэлх хугацааны байнга хадгалах хадгаламжийн нэгжийн нийт 209 боть баримт, 2018 оны нөхөн бүрдүүлэлтийн хуваарийн дагуу 2014 оны байнга хадгалах хадгаламжийн нэгжийн 66 боть баримтыг шилжүүлэн өгч, “Төв архивт баримт хүлээлгэн өгсөн, шилжүүлсэн акт”-аар баталгаажуулж ажилласан.

Тус хэлтсийн хэмжээнд удирдах дээд байгууллагаас 2018 оны эхний 11 сард 3850 албан бичгийг хүлээн авч авснаас хугацаатай 2361 албан бичгийн холбогдох албан тушаалтнуудад хүлээлгэн өгч, хариуг хүргүүлэн ажилласан. Удирдах дээд байгууллага болон бусад газар хэлтэс рүү нийт 6283 албан бичгийг боловсруулан хүргүүлэн ажилласан.

Хэлтсийн хариуцсан хороодод байршуулсан телекамерын системийг 2017 оны 12 дугаар сараас 2018 оны 3 дугаар сар хүртэлх хугацаанд Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газартай хамтран түрээсийн шилэн кабелийн урсгалын гэмтлийг засварлах, хэвийн үйл ажиллагаанд оруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн хэлтсийн хэмжээнд ашиглагдаж байгаа албаны суурин болон зөөврийн компьютер түүний дагалдах хэрэгсэл, ашиглалт, аюулгүй байдал, цагдаагийн байгууллагын домайн сүлжээнд холбогдсон эсэх болон давхардсан тоогоор 50 алба хаагчийн компьютерыг форматлах, хэрэглээний программ хангамж суулгах, цагдаагийн байгууллагын домайн сүлжээнд холбож, хэрэглэгчийн эрхээр нь нэвтрүүлэн цагдаагийн байгууллагын хэмжээнд ашиглагдаж байгаа Microsoft Lync, Outlook програм хангамжуудын тохиргоог хийж, принтерыг таниулан, шаардлагатай тохиолдолд нэмэлт тохиргоо болон программ хангамжийг суулгаж хэвийн үйл ажиллагаанд оруулж ажилласан.

Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтсээс зохион байгуулсан дүүргийн хэмжээний “Объект, субъектын цахим зураглал”-тай болох ажлын хүрээнд хэлтсийн хариуцсан хороодын хэсгийн байцаагч, хороон цагдаа нараас 713 мэдээллийг нэг бүрчлэн Google earth програм дээр шивж оруулах ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн бөгөөд ЦЕГазрын даргын тушаалаар энэ ажлыг үргэлжлүүлэн хийх ажлын хэсэгт орон ажиллаж байна.

Алба хаагчийн нийгмийг асуудлыг шийдвэрлэх зорилгоор дүүргийн 10 алба хаагчийг газартай болгуулах саналыг дүүргийн газрын албанд хүргүүлсэн. Орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамрагдах алба хаагчдын судалгааг гаргаж, Нийслэлийн цагдаагийн газарт хүргүүлсэн.

Хэлтсийн төв болон хоёрдугаар байрны таазнаас дусаал гоожиж байсан жижиг онгорхойнуудыг засварлаж, мөн жижүүрийн шуурхай албаны өрөөг 900,000 төгрөгөөр тохижуулан алба хаагчдын ажиллах тав тухтай нөхцөлийг бүрдүүлсэн. Хөдөлгөөнт эргүүлийн автомашин 4, жижүүрийн 3, эргүүл хяналт шалгалтын 1, эрүүгийн цагдаагийн тасгийн 1, мөрдөн байцаах тасгийн 1, хэлтсийн даргын 1 нийт 10 автомашиныг Цагдаагийн ерөнхий газрын Авто баазаас гаргасан хуваарийн дагуу үйлчилгээнд оруулсан. Эрүүлжүүлэх саатуулах байр, хэлтсийн гадна шатыг 5 сая төгрөгөөр засварлаж, алба хаагчдыг ая тухтай ажиллах болон иргэдэд үйлчлэх ая тухтай орчныг бүрдүүлсэн.

Тус хэлтсийн алба хаагчдын хорт зуршлын талаар тандалт судалгааг гаргахад алба хаагчдын 42 алба хаагчаас архины асуумж судалгаа, скрининг тестээр судалгаа хийлгэн үр дүнгийн талаар хэлтсийн алба хаагч нарт танилцуулахад архины хамааралттай алба хаагч байхгүй байсан.

Тус хэлтсийн алба хаагчдад Аюулгүй байдал судлалын доктор, тамхи, архины шалтгаант эмгэгийн судлалын төвийн тэргүүн Ж.Цогтсугараар “Архинд донтох эмгэг” сэдвээр Дүүргийн Эрүүл мэндийн төвийн эмч Ч.Бямбасүрэнгээр “Хорт зуршил, түүний

үр дагавар” сэдвээр сургалтыг давхардсан тоогоор 186 алба хаагчдад зохион байгуулсан.

Баянзүрх дүүргийн “Улаанзагалмайн нийгэмлэг” төрийн бус байгууллагатай хамтран “Анхны тусламж, түүний төрлүүд” сэдвээр, Дүүргийн Эрүүл мэндийн төвийн халдвар судлалын төвтэй хамтран Тарваган тахал өвчний тухай ойлголт, урьдчилан сэргийлэлт”, “Халдварт өвчний тухай ойлголт, урьдчилан сэргийлэлт”, “Амьсгалын замын халдварт өвчин, урьдчилан сэргийлэлт” сэдвээр Э.Нандинцэцэг, Ч.Бямбасүрэн нар мэдээлэл хийж, дадлага сургуулилтыг нийт давхардсан тоогоор 329 алба хаагчид зохион байгуулсан.

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран алба хаагчдыг болон тэдний гэр бүлийг гэрийн хаяг харгалзахгүйгээр үнэ төлбөргүй, оочир үүсгэхгүйгээр ажлын бус цагаар эрүүл мэндийн үзлэгт 102 алба хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан алба хаагчдад зөвлөгөө өгч, цаашид нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх шаардлагатай болон эмчилгээ хийлгэх чиглэлээр зөвлөгөө өгсөн. Мөн алба хаагчдыг элэгний хатуурал, хорт хавдрыг үүсгэгч элэгний В, С вирусын халдварыг илрүүлэх шинжилгээнд 108 хамруулсанаас 4 алба хаагч элэгний В вирустэй байсныг Улаанбаатар Сонгдо эмнэлэгт вирус тоолуулах шинжилгээнд бүрэн хамруулж, эмчилгээ хийлгэж байна. Элэгний В вирус илрээгүй алба хаагчдаас өөрсдийн саналаар 12 алба хаагчийг Халдварт өвчин судлалын Үндэсний төвийн Дархлаажуулалтын алба, дүүргийн эрүүл мэндийн төвтэй хамтран В вирусын гепатит-ын дархлаажуулалтын нэгдүгээр тунд хамруулаад байна. Тарваган тахлын дархлаажуулалтын вакцин хийлгэхэд хориглох заалтад хамаарахгүй 41 алба хаагч хамрагдсан ба алба хаагчдын нэрсийг нотломжийн хамт Нийслэлийн цагдаагийн газарт хүргүүлэн ажилласан.

Тус хэлтсийн ажлын байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийн талаар мэргэжлийн хянатын газрын улсын байцаагчийн 2017 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 02-07-383/62 дугаартай “Барилгуудын ашиглалт төлөв байдлын тухай” дүгнэлт гаргуулсан ба уг дүгнэлтийн хугацаа дуусаагүй ба тус хэлтсийн эрүүлжүүлэх саатуулах байранд хортой нөхцөлд ажилладаг тул агаар чийгшүүлэгч аппарат 2 ширхэгийг авч байруулан ажиллуулж байна. Эргүүлийн үүрэг гүйцэтгэдэг хөдөлгөөнт эргүүлийн 32 алба хаагчдад амны хаалт өгсөн.

Алба хаагчдын бие бялдарыг хөгжүүлэх, бэлтгэлжилтийн түвшинг нэмэгдүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Баянзүрх дүүргийн 16 хороонд байрлах Өнөр бүл төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулан долоо хоног бүрийн “Лхагва” гарагт нийт алба хаагчдыг спортоор хичээллэх боломжийг хангасан.

Энэ онд сард бие бүрэлдэхүүний дундын сангаас алба хаагчдын нийгмийн асуудал, соён гэгээрүүлэх ажилд нийт 10,124,000 төгрөгийг тус тус зарцуулсан. Тасаг албад сар бүр хамт олны хурлыг зохион байгуулж, алба хаагчдынхаа ажлын үр дүнг хэлэлцэн дүгнэж, ажлын байрны зорилго зорилт, үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлсэн давхардсан тоогоор 149 алба хаагчийн албан тушаалын цалинг 5-20 хувь нэмж, 136 алба хаагчийн сарын үндсэн цалинг 5-20 хувь бууруулж олгосон.

Цагаан сарын баярын хүлээн авалт, хүндэтгэлийн арга хэмжээ, ахмадуудын гарын бэлгэнд нийт 1,900,000 мянган төгрөг зарцуулсан.

Энэ онд 2 алба хаагчийн аюулгүй байдалд халдсан, мэдээ, мэдээлэл бүртгэгдсэн бөгөөд тухайн үйлдэлд нь мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, шүүхээр шийдвэрлүүлсэн.

1.2. Хүний нөөцийн талаар

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/46 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2018 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-ний дагуу 2018 онд сургалтанд хамрагдах алба хаагчдын нэрсийг тасгуудаас авч, нэгтгэн баталгаажуулж, ЦЕГ-ын Сургалтын төвд

хүргүүлэн хуваарийн дагуу 46 алба хаагч, офицер албан тушаал /ажлын байр/-ын сургалтанд 1 алба хаагчийг тус тус хамруулсан.

Хууль сахиулах их сургуулийн эчнээ 3 жилийн хөтөлбөрийн сургалтанд 1, мөн сургуулийн Ахисан шатны сургуулийн магистрын хөтөлбөрт 2 алба хаагчийг хамруулсан.

ЦЕГ-ын даргын 2018 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2018-2019 онд явуулах албаны сургалтын үлгэрчилсэн хөтөлбөр”-ийн дагуу тус хэлтсийн даргын баталсан албаны сургалтын календарчилсан төлөвлөгөөнд тусгагдсан мэдвэл зохих хууль тогтоомж, алба хаагчийг хөгжүүлэх, мэргэжлийн ур чадварын болон дадлагажуулах чиглэлээр 2018 онд 31 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 3315 алба хаагчийг хамруулсан.

Алба хаагчдын бие бялдарыг хөгжүүлэх, өөрийгөө болон бусдыг аливаа эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чадвар эзэмшүүлэх, нийтийн хэв журам хамгаалах Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны хамгаалалтын газарт нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хамгаалалтыг хамгаалалтын сургагч багш нар хамгаалалтын хувцас бамбайг хэрхэн өмсөж хэрэглэх, олон нийтийг хамарсан арга хэмжээний үед бүслэх, тараан байрлуулах, дагалдах, хаалт хийх хэлбэрээр алба хаагчид хамгаалалтад хэрхэн ажиллах талаар 9 цагийн сургалтанд алба хаагчдыг бүрэн хамруулсан.

Шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон хууль, тогтоомж, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам болон бусад эрх зүйн актын талаарх мэдээллийг алба хаагчдад шуурхай хүргэх 3 удаагийн сургалтанд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий бүх алба хаагчдыг бүрэн хамруулж, гарын авлага, материалаар хангасан.

Хэлтсийн гадаад хэлний мэдлэгтэй алба хаагчдын судалгааг гаргаж, Оросын холбооны улсын их, дээд сургууль, Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суугаа Элчин сайдын яамнаас тус Улсын Засгийн газрын 2018 оны олон улсын хууль сахиулах боловсон хүчин бэлтгэх чиглэлийн баклавар болон магистрын хөтөлбөрт болон Япон улсын JICE Олон улсын хамтын ажиллагааны төвөөс Хүний нөөцийг хөгжүүлэх JDS тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргасан алба хаагчийн нэрсийг тухай бүр хүргүүлсэн. Мөн Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсын НҮБ-ын энхийг сахиулах “UNMISSUNMISS” ажиллагаанд үүрэг гүйцэтгэх Монгол Улсын Зэвсэгт хүчний 8 дугаар ээлжийн мотобуудлагын батальоны бие бүрэлдэхүүнд орж үүрэг гүйцэтгэх цагдаагийн алба хаагчдын сонгон шалгаруулалтад оролцуулж, 1 алба хаагч Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар ажлаас чөлөөлөгдөн үүрэг гүйцэтгэж байна.

Тус хэлтсээс алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон гэр бүлийн гишүүдийн хамт хөгжилтэй өнгөрүүлэх, танин мэдэхүйн мэдлэгийг дээшлүүлэх, ажлын ачаалал, стресс ядаргааг тайлах болон Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/82 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Соёл, соён гэгээрүүлэх ажил” /код 940/ -ын 940.2.1-д заасны дагуу нийт бие бүрэлдэхүүний дунд соёлын үйл ажиллагаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах төлөвлөгөөг гаргаж батлуулсан.

Алба хаагчдын ажлын ачаалал, стресс ядаргааг тайлах, ажиллах урам зоригийг нэмэгдүүлэх зорилгоор сар бүрийн 15-ны өдөр тухайн сард төрсөн алба хаагчдад хорвоод мэндэлсэн өдрийн баярын мэндийг хүргэж, хүндэтгэл үзүүлэн хэлтсийн зааланд нийт бие бүрэлдэхүүний дунд дурсамж хадгалуулах арга хэмжээг 2018 оны 01 дүгээр сараас эхлэн зохион байгуулж хэвшсэн. Арга хэмжээнд жижүүрийн бүрэлдэхүүнээс бусад бүх алба хаагчдыг хамруулан арга хэмжээг зохион байгуулж байна.

Хэлтсийн бие бүрэлдэхүүний танин мэдэхүй, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх, алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор цагдаагийн алба

хаагчийн ёс зүйн дүрэм болон чөлөөт сэдвээр асуулт, хариултын “АХА” тэмцээн, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 2018 оны 05 дугаар сарын 31-ний өдөр тус цагдаагийн хэлтсийн алба хаагчдын 82 гэр бүлийн, 200 хүүхдийг оролцуулан хүүхдийн баярын арга хэмжээ зэрэг 30 удаагийн арга хэмжээнд 3621 алба хаагчийг хамруулсан. Мөн алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 7 хоног бүрийн Лхагва гаригт албаны бэлтгэл хийх, спорт зааланд гар бөмбөг, сагсан бөмбөг тоглох нөхцөлөөр хангасан.

Тус хэлтэс нь Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/134 дүгээр тушаалаар нийт 193 алба хаагч буюу 95 офицер байхаас 93, 89 ахлагч байхаас 89, энгийн 9 алба хаагчийн орон тоотой ажиллаж, дутуу орон тоо 9 хүний нөөцийн нөхөн хангалт 95,3 хувьтай байна. 2018 оны эхний 10 сард офицер 7, ахлагч 18 алба хаагч шинээр томилогдож, 4 алба хаагч дэвшин томилогдож, 12 алба хаагч шилжин ирж, 3 алба хаагч чөлөөлөгдөж, 14 алба хаагч шилжин ажилласан.

Тус хэлтсээс 2017 онд ажлын үзүүлэлтээрээ А, В үнэлэгдсэн 2018 онд албан тушаал дэвшүүлэх нөөцөд бүртгэгдэх хүсэлт гаргасан болон болзол шаардлагыг хангасан 19 алба хаагчийг нөөцөд оруулах боломжтой эсэхийг “Албан тушаал дэвшүүлэх /код-909/”-д заасны дагуу судлан шаардлага хангасан алба хаагчдыг албан тушаал дэвшүүлэх нөөцөд авах жагсаалтын дагуу холбогдох судалгааг гарган Нийслэлийн цагдаагийн газарт хүргүүлсэн.

“Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх 6 бүлэг 35 заалт бүхий салбар төлөвлөгөөг хэлтсийн даргаар батлуулан биелэлтийг 92,6 хувьтай, “Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх 4 бүлэг 15 заалт бүхий төлөвлөгөөний биелэлтийг 96,6 хувьтай дүгнэж, тогтоосон хугацаанд Нийслэлийн цагдаагийн газарт хүргүүлсэн.

"Авлигатай тэмцэх тухай хууль"-д зааснаар Улсын Их Хурлаас батлан гаргасан "Албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах журам", "Хөрөнгө орлогын мэдүүлгийн маягт"-ын дагуу 92 алба хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг цахимаар шинэчлэн авч, 92 алба хаагчийн мэдүүлгийг баталгаажуулан Нийслэлийн цагдаагийн газрын Хүний нөөц сургалтын хэлтэст хүргүүлэн ажилласан.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэгт заасны дагуу 2018 онд шинээр томилогдсон 7 офицер, албан тушаал өөрчлөн томилогдсон 7 офицер, дэвшин томилогдсон 5 алба хаагчаас хөрөнгө мэдүүлгийг хуулийн хугацаанд авсан ба хөрөнгө орлогод их хэмжээний өөрчлөлт орсон, хуульд заасан хугацаанаас хожимдуулж мэдүүлсэн алба хаагч байхгүй.

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Цагдаагийн алба хаагчдын авлига, хээл хахууль, хүнд суртлын талаар мэдээллийг 126 тусгай дугаарын утсаар хүлээн авч байгаа талаарх” мэдээллийг хэлтсийн “*bayanzurkh-1.police.gov.mn*” цахим, “Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн нэгдүгээр хэлтэс” нэртэй фейсбүүкийн пэйж хуудас болон иргэдийн хүлээх танхимд байрлуулсан мэдээллийн дэлгэцээр олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан.

1.3 Санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр.

Баянзүрх дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс 20,3 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, 1,8 сая төгрөгийн бараа материал хөрөнгийн санхүүжилтээр авсан.

Тус хэлтэс нь 2018 онд нийт 2,3 тэр бум төгрөгийн төсөв батлагдаж, жилийн эцсийн байдаар 2,3 тэр бум сая төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоор 27,9 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн ба нийт 2,3 тэр бум төгрөгийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу холбогдох хууль, журам, зааврын дагуу зарцуулан ажилласан.

Тайлант хугацаанд цалингийн зардалд 2,1 тэр бум төгрөг, НДШимтгэлд 41,6 сая төгрөг, тогтмол зардал болох Түлш халаалтын зардалд 18,1 сая төгрөг, гэрэл цахилгааны зардалд 29,1 сая төгрөг, цэвэр бохир усны зардалд 4,9 сая төгрөг, шатах тослох материалын зардалд 62,5 сая төгрөг, бичиг хэргийн зардалд 12,3 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 10,1 сая төгрөг, 24 цагаар үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын хоолны зардалд 1 хүнд 5,0 мянган төгрөг нийт 28,7 сая төгрөг, эмийн зардалд 300,0 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардалд 1,4 сая, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 2,0 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 13,5 төгрөгийг тус тус зарцуулж, нийт 2,3 тэр бум төгрөгийн зардал гаргаж ажилласан.

Мөнгөн хөрөнгө, бараа материал, шатахууны тайлан, холбогдох журналуудыг тус бүрд нь хөтөлж, няраваар сар бүр тайланг гаргуулан, тулган шалгаж баталгаажуулсан. Мөн нийт ширхэг 5634 шийтгэлийн хуудсаар 225,8 сая төгрөгийн орлогыг орон нутгийн хүү торгуулийн дансанд төвлөрүүлсэн.

Эрүүлжүүлэгдсэн хүмүүсийн төлбөр төлөлтөнд хяналт тавьж, сар бүр тайланг хүлээн авч харилцахын хуулгатай тулган баталгаажуулж нийт 27,9 сая төгрөгийг байгууллагын 100200012005 тоот дансанд төвлөрүүлэн ажилласан.

Төсвийн орлого зарцуулалт болон тайлагналын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, төсвийн орлого ба зарцуулалтын мэдээ, төсвийн хэмнэлт, хэтрэлтийн шалтгаан тайлбар, 2017 оны санхүүгийн тайлан, нийслэл дэх төрийн аудитын байгууллагаас Цагдаагийн хэлтсийн санхүүгийн тайлан балансад үзүүлсэн аудитын итгэмжлэл, 2018 оны батлагдсан төсвийн хуваарь, байгууллагын үйл ажиллагаа, хөрөнгө зарцуулахтай холбогдон гарч байгаа тушаал, 5 сая дээш төгрөгөөс үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ, худалдан авалт зэрэг мэдээ мэдээллүүдийг цахимаар болон файл хэлбэрээр 2,3 тэр бум төгрөгийн санхүүжилт, 27,9 сая төгрөгийн өөрийн орлого, 2,3 тэр бум төгрөгийн зарлагын гүйлгээнүүдийг шилэн дансны <http://shilendans.gov.mn/> сайтад байршуулсан. Мөн иргэдийн хүлээлгийн танхимд байрлах мэдээллийн самбарт санхүүгийн мэдээллүүдийг тогтмол байршуулж хэвшсэн.

1.4 Сахилга, хариуцлага, дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын чиглэлээр

Тус хэлтсээс 2018 оны эхний 11 сарын байдлаар 21 офицер, 8 ахлагч бүрэлдэхүүнээс сахилгын шийтгэл авагдсан нь бие бүрэлдэхүүний 16.7 хувийг эзэлж байна. Үүнээс тасаг дарга 2, эрүүгийн мөрдөгч 6, мөрдөгч 7, хэв журмын ажил хариуцсан ахлах офицер 1, хэв журмын офицер 1, хэсгийн байцаагч 1, бусад офицер 2, эргүүлийн цагдаа 2, бусад цагдаа 6 байна. Гаргасан зөрчлөөр нь авч үзвэл: бусад хууль тогтоомж зөрчсөн 3, ажлын хариуцлага алдсан 10, ЭХХШТХ зөрчсөн 4, ажил тасалсан 6, цагдаагийн алба хаагчийг сахилгын дүрэм зөрчсөн 2, цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм зөрчсөн 3, үүрэг даалгавар үл биелүүлсэн 1 зөрчил байна. Сахилга ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлөөр нь авч үзвэл: Хувь хүний буруутай үйл ажиллагаа 23, ажлын ачаалал, стресс 6 байна. Сахилгын шийтгэлийн төрлөөр нь авч үзвэл: Сануулах 6, албан тушаалын цалингийн хэмжээг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах 19, цагдаагийн цол бууруулах 2, цагдаагийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах 2 шийтгэл оногдуулсан байна.

Сахилгын зөрчлийг тухайн байгууллагын дотоод хяналтаар 18, ёс журмын хяналтаар 1, гадны хяналтаар 1, төрийн байгууллагаас ирүүлсэн албан бичиг, материалаар 9 зөрчил илэрч, Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар 5, тус хэлтсийн даргын тушаалаар 20 алба хаагчид сахилгын шийтгэл оногдуулсан байна.

Алба хаагчаас гаргаж буй сахилга ёс зүйн зөрчлийг тогтоох, шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор сахилгын зөрчил бүрт албаны шалгалт явуулж, дүнг “Ёс зүйн зөвлөл”-өөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулж, хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулж хэвшсэн.

Хууль зүйн сайдын 2017 оны “Алба хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх тухай” 01 тоот албан даалгавар, ЦЕГ-ын даргын 2017 оны 01 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор алба хаагч нарт сургалт орж, нотломж үйлдэн, хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг батлуулан биелэлтийг улирал, хагас, бүтэн жилээр гаргаж Нийслэлийн цагдаагийн газрын Хяналт шалгалт, үнэлгээ, ёс журмын хэлтэст хүргүүлсэн.

Тус газрын алба хаагчдаас сахилга, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр ирүүлсэн ажлын чиглэл, үүргийг хэрэгжүүлэх, зөрчихгүй байх талаар 8 заалт бүхий баталгааг 170 алба хаагчаас, бичгээр гаргуулан авсан. Алба хаагчдын сахилга, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр сахилгын хариуцлагын зөвлөгөөнийг зохион байгуулж, зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, тасаг, хэсгийн дарга, ахлах байцаагч нараас 18 алба хаагчидтай ганцаарчилан уулзаж, алдаа дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч, давхардсан тоогоор 41 алба хаагчийн ажлыг шалган зааварчилж, 1615 алба хаагчдад үүрэг, даалгавар өгч биелэлтийг тооцон ажилласан. Мөн алба хаагчдын ажлын цаг ашиглалтын судалгааг гаргаж, ажлын цаг ашиглалт хангалтгүй, сахилга ёс зүйн зөрчилд холбогдох магадлалтай 18 алба хаагчидтай ганцаарчлан уулзаж, зөвлөгөө өгч ажилласан.

Алба хаагчдын сэтгэц, зан үйлийн эмгэгээс урьдчилан сэргийлэх, сэтгэл зүйн мэдлэг олгох, алдаа дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх, ажлын амжилт гаргахад нөлөөлөх стресс, бухимдал тайлах, сэтгэл хөдлөлөө хянаж зохицуулах, чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх мэдлэгийг олгуулах, хэвшүүлэх зорилгоор Монгол улсын багшийн Их сургуулийн сэтгэл зүйн багш доктор Н.Нарантунгалагаар сургалтыг оруулж, сэтгэл зүйн тест авч алба хаагчдын сэтгэл зүйн хувийн хэргийг баяжуулсан. Хамт олны халуун дулаан уур амьсгалыг бэхжүүлэх, нөхөрсөг, найрсаг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор “Эмэгтэйчүүдийн зөвлөл”-өөс алба хаагчдын төрсөн өдрийн судалгааг гаргаж, тухай бүрт нь алба хаагчдын төрсөн өдрийг тэмдэглэн, баяр хүргэн Цагдаагийн ерөнхий газрын Сүлд чуулгатай хамтран дууны мэндчилгээ хүргэх, бялуу хуваах арга хэмжээ зохион байгуулж хамт олноороо тэмдэглэж хэвшсэн.

Алба хаагчдыг гэмт хэрэг, захиргааны зөрчилд холбогдох, өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”, “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”, Хүний эрхийн үндэсний комиссын рефрент Г.Золзаяа “Хүний эрх ба Жендэр”, “ЛГБТ-ийн тухай ойлголт”, “Нийтийн эмх замбараагүй байдлын дадлага, сургалт” зэрэг сэдвүүдээр 4 удаагийн 4 цагийн сургалтыг зохион байгуулсан.

Цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой иргэд, байгууллагаас Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 11-11 төв, “check my service аппликейшн”, “Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв”-д 2018 оны эхний 11 сарын байдлаар нийт 49 гомдол, хүсэлт, талархал ирүүлсний гомдол 19, хүсэлт 14, талархал 16 тус тусыг хүлээн авч, бүртгэлийг хөтөлсөн. Алба хаагчтай холбоотой 16 талархлыг нийт бие бүрэлдэхүүнд танилцуулж, иргэд байгууллагаас ирүүлсэн гомдол, хүсэлтийг хуулийн хугацаанд шалгаж, холбогдох алба хаагч нарт албаны шалгалтыг явуулж, буруутай үйлдэл тогтоогдсон 4 алба хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалинг 1 сар 10-20 хувь бууруулах, 2 алба хаагчид сануулах сахилгын шийтгэл оногдуулж хариуцлага тооцон ажилласан. Цагдаагийн байгууллага, алба хаагч, түүний үйл ажиллагаатай холбоотой гомдлыг ажлын цагаар хэлтэс, тасаг, хэсгийн дарга нар, ажлын бус цагаар тухайн өдрийн ерөнхий эргүүл хүлээн авч, санал, гомдлыг байгууллагын удирдлагад танилцуулан цохолт хийлгэн шийдвэрлэсэн.

Байгууллага, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, саармагжуулах чиглэлээр мэдээллийн санд баяжилт хийж, хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Орон тооны бус ажлын хэсгийн ахлагчаас хэлтсийн дотоод аюулгүй байдлыг хангах

чиглэлээр тасгийн дарга нар болон алба хаагч нарт 13 чиглэлээр 19 зааварчилгааг хүргүүлж биелэлтийг тооцож ажилласан.

Алба хаагчдыг гэмт хэрэг, захиргааны зөрчилд холбогдох, өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр “Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт”, “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”, “Алба хаагч гэмт хэрэг, зөрчилд холбогдсон өртөж хохирсон талаар мэдэгдэх, сан бүрдүүлэх, ашиглах”, “Тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх” “Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, эрсдэлийн удирдлага” зэрэг сэдэвт сургалтанд давхардсан тоогоор 3315 алба хаагчийг хамруулсан.

Цагдаагийн хэлтсийн эрсдэлийн үнэлгээг хэлтсийн даргын тушаалаар томилогдсон Эрсдэлийн үнэлгээ хийх орон тооны бус багаас хийж, эрсдэлийн санд баяжилт хийн, байгууллагын эрсдэлийг тооцон хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулсан. Цаашид эрсдэлүүдийг хэрхэн шийдвэрлэх талаар ярилцлага зохион байгуулж, гарсан санал, санаачлагыг нэгтгэн 2018 онд эрсдэлийг сааруулах үйл ажиллагаа буюу хариу арга хэмжээг авах төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажилласан.

Тус газрын тасаг, хэсгийн дарга нараас Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 246 дугаар тушаалаар батлагдсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах /код-112/-ын дагуу алба хаагчдаас гаргасан сахилга, ёс зүйн зөрчилд албаны шалгалтыг тал бүрээс нь бүрэн гүйцэт, бодитой явуулж, алба хаагчийн гаргасан зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоон, газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж хэвшсэн. Энэ онд тус хэлтсийн 81 алба хаагчдад холбогдуулан 42 удаа албаны шалгалт явуулж, гаргасан зөрчлийн шалтгаан нөхцөлийг судлан тогтоож, эрх бүхий алба хаагчдаас дахин зөрчил, дутагдал гаргахгүй байх зорилгоор 16 алба хаагчдад зааварчилгаа өгч, хариуцсан алба хаагчдад тавих хяналтыг сайжруулах чиглэлээр тасгийн дарга нарт хугацаатай үүрэг хүргүүлж, биелэлтийг тооцон ажилласан.

Хоёр. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

2.1. Нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийн хүрээнд:

Зөрчлийн шинжтэй өргөдөл, гомдол хүлээн авч шалган шийдвэрлэж, гудамж, талбай, олон нийтийн газар болон ахуйн хүрээнд иргэдийн амгалан тайван байдал алдагдуулж, танхайрсан зөрчил гаргасан 5068 иргэнд 175,863,500 төгрөгөөр, 267 аж ахуй нэгж, байгууллагад шийтгэлийн хуудсаар 37,045,000 төгрөгөөр торгож, шүүхээр 345 хүнийг шүүхийн шүүгчийн захирамжаар 7-30 хоног баривчилж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх иргэдэд хууль, эрх зүйн талаар ухуулга, яриа таниулга, зөвлөгөө өгч ажилласан. Мөн 2018 онд нийт 301 гэмт хэрэг илрүүлж, 29 гэмт хэргийг таслан зогсоож, оршин суугаа газраасаа сураггүй алга болсон 454 иргэн, 79 эд зүйлийг олж тогтоон ажилласан.

Иргэд, байгууллага аж ахуйн нэгжээс цагдаагийн байгууллагад ирүүлсэн гомдол мэдээллийг шалгах эрх бүхий алба хаагчид 3116 өргөдөл, гомдол хүлээн авч шалгаснаас, 1253 буюу 40,2 хувийг зөрчлийн хэрэг үүсгэсэн, 1843 буюу 59,1 хувийг зөрчлийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтай прокурорт хүргүүлж, 14 буюу 0,4 хувийг харъяаллын дагуу шилжүүлсэн. 217 хэргийг хэрэгсэхгүй болгож, оршин суугаа газраасаа сураггүй алга болсон гэх 416 иргэнийг олж тогтоож 7 иргэний холбогдох материалыг эрүүгийн цагдаагийн тасагт шалгуулахаар шилжүүлж, 293 эд зүйлийг цагдаагийн байгууллагын санд бүртгэж эрэн сурвалжилж ажилласан.

Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд амарч зугаалах үедээ гар утсаа гээгдүүлэх, хулгайд алдах зөрчлөөс урьдчилан сэргийлж 17:00 цагаас 23:00 цагийн хооронд өдөр тутам 2-с доошгүй алба хаагчдыг нөхцөл байдалд тохируулан ажиллуулсан бөгөөд үүний үр дүнд 14 хоногт нийт 369 гэмт хэрэг, зөрчил бүртгэгдэж байсан бол, сүүлийн 14 хоногт 330 гэмт хэрэг, зөрчил бүртгэгдэж 39 гэмт хэрэг, зөрчлөөр буюу 10.6% буурсан үзүүлэлттэй байна.

Тус хэлтсээс 2018 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Автомашин”, “Хаус”, “Сургууль-аюулгүй орчин”, “Хяналт-1”, “Хамтын ажиллагаа”, “Эмзэг хяналт шалгалт”, “Илрүүлэлт”, “Эргүүл”, “Хоёрдогч түүхий эд”, “Нийтийн байр”, “Архигүй өдөр”, “Тамхины хяналт”, “Хуулийн хэрэгжилт”, “Аккумулятор”, “Шөнийн хяналт”, “Хөршийн хяналт”, “Хамтын ажиллагаа”, “Сар шинэ”, “Нийтийн эргүүл”, “Эргүүл-1000”, “Тамхины ишгүй байгууллага-Тамхигүй орчин”, “Ломбард”, “Хориглосон өдөр” зэрэг 23 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, зочид буудал, архи согтууруулах ундаа худалддаг түүгээр үйлчилдэг 205, саун массаж 32, ТҮЦ 83, цахим тоглоом 18 нийт 338 удаа нэгдсэн үзлэг шалгалтыг зохион байгуулж, үр дүнг тооцсон.

Камер, техникийн хяналтын үйл ажиллагааны талаар

Телекамерын 7 алба хаагч 24 цагаар нийт 6240 цагийн үүрэг гүйцэтгэж, Баянзүрх дүүргийн 1,3 хэлтсийн нийт 53 камераас өнөөдрийн байдлаар 32 камерт хяналт тавьж ажилж байна. Нийт 32 камерт давхардсан тоогоор 85900 гаруй удаа хөдөлгөөнийг хянаж, камерийг сэжиг бүхий объектууд руу харуулж байршуулан зохих хяналтыг тавьж ажиллаа. Одоо ажиллаж байгаа камераас Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэс 21, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн гуравдугаар хэлтэс 11 камер тус бүр ажиллаж байна. Үүнээс хэлтсийн нутаг дэвсгэрт байрлах 26 камераас 5 камер, 3-р хэлтсийн 27 камераас 16 камер ажиллахгүй байна. Зарим нэг камер нь хэвийн бус, тасалдаж олон хоног тасарч улмаар ажиллах нөхцөлд саад болох магадлал өндөр байдаг. Ажиллахгүй байгаа үлдсэн олон камер нь "Скай ворлд" ХХК-тай тооцоо хийгдэж дуусаагүй, том дэлгэц нь дутуу ирсэнээс бүрэн ажиллах боломжгүй гэх мэт шалтгаанаар өнөөдөр компьютерийн 1 дэлгэц дээр 32 камераар хяналтыг гүйцэтгэж байна. Нийслэлийн Баянзүрх дүүргийн цагдаагийн 1,3 дугаар хэлтсийн нутаг дэвсгэрт байршуулсан 53 камераас одоо ажиллаж байгаа 32 хяналтын камераар 2018 оны байдлаар нийт 355 удаа холбогдох албан тушаалтны зөвшөөрлөөр 140 цагийн бичлэг шүүлгүүлж нийт 53 удаа гэмт хэрэг үйлдэх гэж байх үйлдэл дээр нь илрүүлэн холбогдох алба хаагчдад нь хүлээлгэн өгч таслан зогсоосон. Камерын хяналтаар 106 гэмт хэрэг, 57 зөрчил илрүүлэн ажилласан байна.

Цагдаагийн байгууллагийн нэгдсэн санд хэсгийн байцаагчийн захиргааны үүргийн хүрээнд хариуцсан хорооны нутаг дэвсгэрийн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 453 мэдээ, мэдээллийг санд оруулах ажлыг зохион байгуулсан.

Захиргааны хяналтын 136 этгээдэд хяналт тавьж, сар бүрийн 15-ны дотор хэсгийн байцаагч нар биечлэн уулзаж, хууль зүйн зөвлөгөө өгч дахин гэмт хэрэг зөрчилд өртөж холбогдохгүй байх талаар баталгаа гаргуулан, дүүргийн хяналтын прокурорт хуваарийн дагуу материалыг хянуулан ажилласан.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам журам /код-707/-д заасан хөтлөгдвөл зохих бүртгэл судалгааг бүрэн шинэчилж нэг загварт оруулах ажлыг зохион байгуулж 6 удаа бичгээр зааварчилга өгч биелэлтийг тооцсон. Мөн бүртгэл судалгааг цахим хэлбэрт оруулах ажлын хүрээнд объект субъектын судалгааг эрүүгийн цагдаагийн тасагтай хамтран хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах иргэн,

аж ахуй нэгж бүрийн дэлгэрэнгүй мэдээллийг цахимд оруулах ажлыг амжилттай хийж гүйцэтгэж байна.

Иргэдээс ирүүлсэн гомдол мэдээлэл, зөрчлийн хэрэгт хийгдвэл зохих ажиллагааны талаар бичгээр нийт 355 хэрэгт зааварчилга өгч зөрчлийн хэргийг түргэн шуурхай хуулийн хугацаанд шийдвэрлэж иргэнд эргэж шийдвэрлэлтийн талаар хариу өгөх ажлыг бүрэн хэвшүүлсэн.

Хариуцсан нутаг дэвсгэрт архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгж, дэн буудал зочид буудал, саун массажны газар, цахим тоглоомын газар, түргэн үйлчилгээний цэгийн цагийн хуваарьт хяналт тавьж архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг түүгээр үйлчилдэг 633 баар, 950 караоке, 201 саун массажны газар, 705 хүнсний дэлгүүр, 796 зочид буудал, 516 дэн буудал, 237 цахим тоглоомын газар, 2561 түргэн үйлчилгээний цэгт давхардсан тоогоор хяналт тавьж, зөрчил гаргасан 190 иргэн, аж ахуй нэгж байгууллагыг шийтгэлийн хуудасаар 43,960,000 төгрөгөөр торгож удаа дараа зөрчил гаргасан 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “МЦ” ХХК-ны “Хаанчлал” баарны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах саналыг 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 30и/2296 дугаартай албан бичгээр, 22 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Сэрх уул” ХХК-ны “Алтан цайз” караоке, “Лакшари Мүүн Лайт” ХХК-ны “Мүүн” диско баарны тусгай зөвшөөрлийг цуцлуулах саналыг Нийслэлийн цагдаагийн газрын дэд бөгөөд Нийтийн хэв журам хамгаалах газарт хүргүүлсэн.

Архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгжүүдэд “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль” болон бусад хууль тогтоомж, Нийслэлийн иргэдийн хурлын тогтоол, Засаг даргын захирамж, шийдвэрийг хангуулах чиглэлээр дүүргийн мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтарсан шалгалт зохион байгуулж 27 аж ахуйн нэгж байгуулагад хяналт тавьж зөрчилтэй 4 байгуулагад мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн мэдэгдэх хуудас өгч, 2 иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг 450000 төгрөгөөр торгож ажилласан.

Тус хэлтсийн эрүүлжүүлэх, саатуулах байр нь 4 эмч, 4 жолооч цагдаа, 12 эрүүлжүүлэх саатуулах байрны цагдаатайгаар үүрэг гүйцэтгэж тус дүүрэг дэх Цагдаагийн нэг, хоёр, гурав дугаар хэлтэс болон Замын цагдаагийн хэлтсүүдээс зөрчил гарган ирсэн иргэдийг хүлээн авч хоногт 30-35 иргэнийг хүлээн авч ажиллаж байна. Энэ онд жилд нийт 10679 иргэн саатуулагдсаныг хүлээн авч хүний амь нас, эрүүл мэндийг сахин хамгаалж хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

2018 онд эрүүлжүүлэх саатуулах байранд гэмт хэрэг, зөрчил үйлдсэн, нийтийн хэв журам зөрчиж хүргэгдэн ирсэн 10679 хүнийг хүлээн авч, журмын дагуу бүртгэл судалгаанд авч 6145 хүнээс 24,508,879 төгрөгний төлбөр төлүүлэн ажилласан. Хэлтсийн эрүүлжүүлэх байранд гадна үүдний коридор хэсгийн ханны өнгийг сэргээж будаж засварласан. Мөн эрүүлжүүлэх байрны эмч, цагдаа нарт өдөр тутам онцгойлон үүрэг чиглэл өгч эрүүлжүүлэх байранд хүний амь нас, эрүүл мэнд эрсдэхээс урьдчилан сэргийлж цаг тутамд биечилж хяналт тавьж ажиллах талаар үүрэг чиглэл өгч хэрэгжилтэнд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

Эрүүлжүүлэх саатуулах байранд ирсэн иргэдээс эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах шаардлагатай болсон нийт 5230 хүнд эмнэлгийн анхны тусламж үзүүлж, эмнэлгийн түргэн тусламжид 235 хүнийг үзүүлсэн.

Саатуулах байр, жижүүр, авто эргүүлийн алба хаагчдыг цаг үеийн нөхцөл байдалд тохируулан хариуцсан нутаг дэвсгэрийн онцлогт хүн хүчээ оновчтой зөв зохион байгуулах зорилгоор 6 цагаас илүүгүй цагаар явган эргүүлээр ажиллуулж, авто эргүүлийн алба хаагчдыг 12/12/48, 24/12, 24/48 цагаар хуваарьт оруулан ажиллуулж

өдөр тутам тасгийн дарга, ахлах байцаагч нарын зүгээс тогтмол хяналт тавин ажилласан. Эргүүлийн үүрэг гүйцэтгэх үед нь алба хаагчдын албаны тусгай хэрэгсэл, хутганаас хамгаалах хантааз, агсамж зэргийг биедээ авч явж байгаад хяналт тавьж өмсөж хэвшүүлсэн.

Хариуцсан нутаг дэвсгэрт үйлдэгдэх хулаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд 2 алба хаагчийг Нийслэлийн цагдаагийн газрын Мөрдөн шалгах газрын хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст сурган дадлагажуулан халаасны хулгайн гэмт хэрэг үйлддэг этгээдүүийг таниулах үйлдсэн гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр 1 сарын хугацаатай ажиллуулахад 27 гэмт хэрэг, 3 эрэн сурвалжлагдсан байсан этгээдийг олж тогтоон харъяа цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгч ажилласан. Мөн халаасны хулгайн гэмт хэрэг ихээр үйлдэгддэг 14 дүгээр хороо, Их орд худалдааны төвийн урд талын автобусны буудал, 13, 22 дугаар хорооны офицеруудын ордны автобусны буудал, 19 дүгээр хорооны автобусны хойд талын автобусны орчмоор 08:00 цагаас 15:00 цагийн хооронд явган эргүүлийг ажиллуулснаар тухайн эргүүлийн орчимд гэмт эхрэг, зөрчил үйлдэгдээгүй.

2018 оны 03 дугаар сард Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас шийдвэрлэсэн 1 автомашиныг Улиастай-113 чиглэлд 16, 24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт ажиллуулсан.

Дүүргийн замын цагдаагийн хэлтэстэй хамтран “Илрүүлэлт оргодол шийдвэрлэлт” нэгдсэн арга хэмжээний хүрээнд 2 удаа хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, арга хэмжээний хүрээнд 2 оргодол илрүүлж, 74 автомашины багаж болон 89 иргэнийг шалгаж ажилласан.

Тасгийн дарга нарыг авто эргүүл дээр үүрэг гүйцэтгүүлэх хуваарийг гарган хэлтсийн даргаар батлуулж, өдөр бүр 18:00 цагаас 20:00 цагийн хооронд үүрэг гүйцэтгүүлж, 12 дуудлага мэдээлэлд очиж, 24 алба хаагчдад зааварчилгаа өгч ажилласан.

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдал, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэхэд Цагдаагийн байгууллагын албадын хамтын ажиллагааг сайжруулах, хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд тээврийн хэрэгсэл ашиглан үйлдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийг шуурхай илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор Баянзүрх дүүргийн Замын цагдаагийн хэлтэстэй хамтран “Хамтын ажиллагаа” нэгдсэн арга хэмжээг 2018 оны 01 дүгээр сарын 04-нөөс 30-ны өдрийн хооронд 7 хоног бүрийн даваа, баасан гарагт Замын цагдаагийн хэлтсийн 4, хэв журмын 4 алба хаагч нутаг дэвсгэрийн хэмжээнд эргүүл, хяналт шалгалтыг зохион байгуулан ажилласнаар 45 автомашиныг шалгаж, 10 хүнийг 250,000 төгрөгөөр торгож, 36 иргэнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ухуулга яриа хийсэн.

Баянзүрх дүүргийн 1, 2, 3 дугаар хэлтэс, Дүүргийн Боловсролын хэлтэс хамтран 2017 оны 12 дугаар сарын 20-ноос 2 сарын хугацаатай “Сургууль-Аюулгүй орчин” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж тус хэлтсийн харъяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд 3 ээлжээр хичээллэдэг Баянзүрх дүүргийн 16 хороонд байрлах 44 дүгээр сургууль, 25 дугаар хороонд байрлах 111 дүгээр сургуулиудад хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийж, захирал, багш, сурагчид болон “School police”-д үүрэг гүйцэтгэж байгаа эцэг, эхчүүдтэй уулзаж, санал, хүсэлтийг нь авч зөвлөгөө өгсөн.

Сар шинийн баярыг холбогдуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн мэдээлэл, шторк, сэрэмжлүүлгийг Нарантуул олон улсын худалдааны төв,

Өгөөмөр зах, Шөнийн зах, Баянзүрх-2 зах Сандэй худалдааны төвийн чанга яригч, узель, “Баялаг Ундраа” төвийн гаднах led дэлгэцээр нийтэд тасралтгүй, давтамжтайгаар мэдээлэх ажлыг зохион байгуулсан. Мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Зөвлөмж”-ийг нийтийн тээврийн хэрэгслийн радио долгионоор олон нийтэд хүргэх зорилгоор явуулсан албан бичигт “Эмсид” ХХК-аас зөвлөмжийг 15 автобусны радио долгионоор цацаж байгаа талаар хариу ирүүлсэн.

Нийтийн хэв журам хамгаалах Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албатай хамтран хороон цагдаа Г.Бат-Эрдэнэ, олон нийтийн цагдаа В.Отгонжаргал нар тус дүүргийн 25 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Төгс дэлгэрэх”, 22 дугаар хороонд байрлах 37 дугаар дунд сургууль, 16 дугаар хороонд байрлах 44, 53 дугаар дунд сургуулийн 40 багш, ажилчид, 980 сурагчдад “Гэмт хэрэг, зөрчлийн талаарх ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх”, “Архидан согтуурахын хор уршиг” сэдвээр 6 цагийн сургалт зохион байгуулж, 2 төрлийн шторкийг үзүүлж, яриа таниулга хийж, сонирхсон асуултанд хариулт өгч, дээрх сэдвээр бэлтгэж хэвлүүлсэн 350 сэрэмжлүүлэг, зурагт хуудсыг тараасан.

Аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр эргүүл, шалгалтыг хэсгийн байцаагч, хороон цагдаа, машинт эргүүл, хэсэг кобаны алба хаагч нарын хамт тогтмол зохион байгуулж, гудамж талбай, олон нийтийн газар, харуул хамгаалалтгүй байрлуулж орхисон автомашинуудад гэмт халдлагад өртөхөөс урьдчилан сэргийлэх, иргэд бүр сонор сэрэмжтэй байх талаар зөвлөмж 314, санамж 408, сэрэмжлүүлэг 716 хувийг хэвлүүлэн иргэдэд тарааж ажилласан.

2018 оны 9 дугаар сард “Дэн буудал”, “Цахим тоглоом”, “Хуулийн хэрэгжилт-2” арга хэмжээнхий хүрээнд тус хэлтсийн харьяа 13, 14, 16, 19, 22, 24, 25, 26 хороодын нутаг дэвсгэрт эргүүлийн чиглэл ажилласан.

Олон нийтийн цагдаагийн ажилтнууд хэсгийн байцаагч, хорооны цагдаатай хамтран давхардсан тоогоор 12 удаа хэргийн газрын хамгаалалтанд ажиллаж, 23 зөрчлийг таслан зогсоож, оршин суугаа газраасаа алга болсон гэх 14 иргэнийг эрэн сурвалжлах ажилд хамтран үүрэг гүйцэтгэсэн.

Хэсгийн байцаагч, хороон цагдаа, олон нийтийн цагдаагийн ажилтан нар нь тус бүр хариуцсан хорооны задгай гэх хаягтай зайдуу, бүлэг бөөгнөрөл үүсгэдэг айл өрх, хороодын эмзэг цэгүүдийн шинэчилсэн судалгааг гаргаж тэдгээр цэгүүдэд тогтмол эргүүлийн үүрэг гүйцэтгэн, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар айл өрхүүдээр давхардсан тоогоор 1410 удаа орж нийт 2160 иргэнд ухуулга яриа таниулга хийж, яриа таниулга хийх чиглэлээр 681 аж ахуйн нэгж байгууллагын 1441 ажилчдад зөвлөгөө өгч ажилласан.

Хөршийн хяналтын бүлэг болон нийтийн эргүүлээс ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авч, холбогдох байгууллагад мэдээлэх, хүргэх, шийдвэрлэх үйл ажиллагааг уялдуулах, “Хөршийн хяналтын бүлэг”-ийн үйл ажиллагаандаа ашиглах гарын авлага, аргачилсан зөвлөмж боловсруулах, нутаг дэвсгэрийн суурьшлийн бүсийн онцлогт тохируулан орон сууцны орц, гудамжаараа сайн дураараа нэгдэн хөршийн хяналт бүлэг байгуулах үйл ажиллагааг дэмжих, хөршийн хяналтын бүлгийн гишүүдэд чадавхижуулах, үйл ажиллагааг нь эрчимжүүлэх чиглэлээр хэсгийн ахлагч 20 урамшилт эргүүлийн 30 иргэн иргэдтэй хамтран эргүүл хийлгэж ажиллаж байна.

Хариуцсан хорооны нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 40 иргэн 20 чиглэлд хэв журмын урамшилт эргүүлээр үүрэг гүйцэтгэх хугацаандаа 36 санамж сэрэмжлүүлэг тарааж, цагдаагийн 102 тусгай утсанд дуудлага 7 удаа өгч, олон нийтийн газар танхайрч байсан 7 иргэнийг машинт эргүүлийн алба хаагч нарт хүлээлгэн өгч арга хэмжээ авхуулж ажилласан. Хариуцсан нутаг дэвсгэрийн ерөнхий боловсролын 8 хорооны нутаг дэвсгэрт байрлах 20 сургуулийн “School police”-ийн үйл ажиллагааг шалгаж, зааварчилга өгч ажилласан.

Захиргааны хяналтын 114 хяналт тавьж сар бүрийн 15-ны дотор хэсгийн байцаагч нар биечлэн уулзаж хууль зүйн зөвлөгөө өгч, дахин гэмт хэрэг зөрчилд өртөж холбогдохгүй байх талаар баталгаа гаргуулан, дүүргийн хяналтын прокурорт хуваарийн дагуу материалыг хянуулан ажиллаж байна.

Хариуцсан нутаг дэвсгэрт гэрээт харуул хамгаалалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийт 106 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, гэрээт харуул хамгаалалтын байгууллагуудын нэгдсэн мэдээллийн цахим сан болох SAS программд мэдээлэлээ шивж оруулах талаар мэдэгдэл өгч хамгаалагч нарын ур чадвар, үүрэг гүйцэтгэлт, албаны тусгай хэрэгсэл ашиглах, шуурхай албаны бүлгийн ирж буй цаг хугацаа зэрэгт хяналт тавин ажилласан.

Нийслэлийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/278 дугаартай захирамж, Нийслэлийн онцгой байдлын газрын даргын баталсан “Галын болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд Нийслэлийн онцгой байдлын газар, Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газартай хамтран 2018 оны 04 дүгээр сарын 04, 05, 06-ний өдрүүдэд хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 8 томоохон зах худалдаа үйлчилгээний төвүүдэд хяналт шалгалтыг явуулж Монгол Улсын Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль, Цагдаагийн ерөнхий газрын даргын 126 дугаар тушаал, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Гэрээт харуул хамгаалалт, хувийн хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ олгох, хяналт тавих” /код-605/-д хэрэгжүүлэхээр 6 аж ахуй нэгжид “Шаардлага” хүргүүлж “Сити классик”, “Нар Мон” ХХК-ний гэрээт харуул хамгаалалтын албад нь зохих зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсныг илрүүлэн Зөрчлийн тухай хуулийн 10.26 дугаар зүйлд заасны дагуу тус бүр 500,000 төгрөгөөр торгож үйл ажиллагааг нь зогсоосон.

Мөн “Дүнжингарав”, “Сөрөг хамгаалалт”, “Сүлдэт хуягт” ХХК-ны гэрээт харуул хамгаалалтын албадын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж сунгах талаар хүсэлт ирүүлснийг хүлээн авч 2017 онд тус цагдаагийн хэлтэстэй хамтарч ажиллаагүй бөгөөд цаашид гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах хүсэлт ирүүлснийг хүлээн авсан талаар тодорхойлолтыг гаргасан.

Хариуцсан нутаг дэвсгэрт Гэрээт харуул хамгаалалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 25 байгууллагын удирдлагуудтай 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдөр хэлтсийн зааланд уулзалт зохион байгуулж Цагдаагийн ерөнхий газрын даргын 2008 оны 126 дугаар тушаалаар батлагдсан “Гэрээт харуул хамгаалалтын байгууллагын алба хаагчдын дүрэмт, хувцасны загвар, өнгө, материалын ялгаа, дүрэмт хувцас өмсөж хэрэглэх журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой саналыг авч, гарсан саналыг нэгтгэж Нийслэлийн цагдаагийн газар хүргүүлж ажилласан.

Нийслэлийн Засаг даргын 2013 оны “Техникийн захуудын талаар авах зарим арга хэмжээний тухай” А/980, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 онд баталсан “Авто цолцолбор барьж байгуулах тухай зарим арга хэмжээний тухай” 29 дүгээр тогтоолыг автозам дагуу худалдаа эрхлэгч 2 аж ахуй нэгж, 6 иргэнд танилцуулан Цагдаагийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн дагуу “Цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаа нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зөрчлийг арилгуулах, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх зорилгоор хүн, хуулийн этгээдэд тодорхой үйлдлээс татгалзах, эсхүл үйлдэл хийх шаардлага тавьж” хуулийн 23.6-д заасны дагуу “Цагдаагийн алба хаагчийн шаардлагыг тухайн хүн, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй” талаар яриа таниулга хийж ажиллаа.

Замын цагдаагийн хэлтэстэй хамтран 2018 оны 05 дугаар сарын 21, 22, 23-ний өдрүүдэд 16, 19 дүгээр хороо “Саруул тэнгэр” 1, 2 хотхоны голын авто замын зөрчих хэсгийн нэгдүгээр эгнээнд удаан хугацаагаар автомашинаа байрлуулахгүй байх, 24 дүгээр хороо Цахлайн тойргоос Эрдэнэ толгойн замын уулзвар хүртэлх зайнд үйлдвэр үйлчилгээ эрхэлж байгаа иргэдэд автозамын нэгдүгээр эгнээнд үйлчлүүлэгч иргэдийн автомашиныг түр зогсолт хийж түгжрэл үүсгэхгүй байхад анхаарч ажиллах талаар чанга яригчаар шаардлага тавьж ажилласан бөгөөд цаашид хороон цагдаа, олон нийтийг цагдаа нарыг эргүүлээр ажиллуулж тогтмол хяналт тавихыг үүрэг болголлоо.

Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд даргын 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 2/24 дугаартай ажлын чиглэлийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж тооллогыг зөвхөн арга хэмжээ нэгдсэн арга хэмжээний үеэр бус тухайн оны эхнээс тасралтгүй тоолж санд оруулж байх ажлын чиглэлийн дагуу 2018 оны эхний хагас хариуцсан нутаг дэвсгэрт бүртгэлтэй галт зэвсгийг тогтмол бүртгэх ажлын хүрээнд нийт 842 галт зэвсгийг бүртгэсэн.

“Эмчилгээ” хэсэгчилсэн арга хэмжээг 2018 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс 19-ны зохион байгуулж байнга архидан согтуурч орчиндоо түгшүүр төрүүлдэг, оршин суух хаяг тодорхойгүй, орон гэргүй тэнэмэл байдлаар амьдардаг архаг архичин 8 иргэнийг шүүхээр оруулж “Албадан эмчлэх төвд” хүргэн өгсөн ба ар гэртээ агсан согтуу тавьж гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг 26 иргэнийг шүүхээр 7-30 хоногоор баривчлах шийтгэл оногдуулсан.

2018 оны 09 дүгээр сарын 01-нээс 09 дүгээр сарын 10-ны хооронд Нийслэлийн ахлахууд болон Баянзүрх дүүргийн нэгдүгээр хэлтэс, хоёрдугаар хэлтэс, гуравдугаар хэлтсийн урьдчилан сэргийлэх ахлахуудын “Хамтарсан” баг “Цахим тоглоом” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Хяналт шалгалтаар цаг хэтрүүлж ажилласан 2 зөрчлийг илрүүлж, Зөрчлийн тухай хуулийн 10.4 дэх хэсэгт зааснаар 2 иргэнд 300,000 төгрөгийн торгох шийтгэл оногдуулсан.

Дүүргийн замын цагдаагийн хэлтэстэй хамтран “Илрүүлэлт оргодол шийдвэрлэлт” нэгдсэн арга хэмжээний хүрээнд 3 удаа хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, арга хэмжээний хүрээнд 3 оргодол илрүүлж, 143 автомашины багаж болон 184 иргэнийг шалгаж ажилласан болно.

Хариуцсан нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдийн амьдрах орчны эрүүл аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр болон “Эмзэг цэг-хяналт шалгалт” нэгдсэн арга хэмжээний хүрээнд архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг түүгээр үйлчилдэг 168 баар, 221 караоке, 81 саун массажны газар, 320 хүнсний дэлгүүр, 218 зочид буудал, 137 дэн буудал, 66 цахим тоглоомын газар, 705 түргэн үйлчилгээний цэгт давхардсан тоогоор хяналт тавьж, зөрчил гаргасан 18 иргэн, аж ахуй нэгж байгууллагыг шийтгэлийн хуудасаар 2500000 төгрөгөөр торгож ажилласан.

Нийтийн хэв журам хамгаалах тасаг нь 2018 онд нийт 31 удаагийн хэв журмын хамгаалалтын төлөвлөгөө, зураглалыг боловсруулан батлуулж ажилласан. Үүнээс Үндэсний их баяр наадам, ардын хувьсгалын ойн баяр, Цагаан сар, Шинэ жил, Хүүхдийн баяр, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баяр, Их эзэн Чингис хааны өдрийн баяр, амралтын өдөр зохион байгуулагдах арга хэмжээний төлөвлөгөө, зураглалыг боловсруулан 11 батлуулж, хамгаалалтыг давхардсан тоогоор 688 алба хаагч, ямар нэгэн зөрчил дутагдалгүй зохион байгуулж мэдээг тухай бүр Нийслэлийн цагдаагийн газарт хүргүүлсэн.

Тус хэлтсээс Дүүргийн тамгын газрын байранд 10 удаа, нам улс төр, иргэний байгууллагаас хууль бус жагсаал цуглаан 5, төрийн өндөр дээд хэмжээний уулзалтын үеийн хамгаалалтад 7 удаа, өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн хамгаалалтад 4 удаа, олон улсын уралдаан тэмцээний үеийн хамгаалалтад 5 удаа тус тус хэв журам

сахиулан хамгаалалтыг зохион байгуулсан. Дээрх арга хэмжээнд хяналт тавьж, дүнг нэгтгэн ажилласан тухай танилцуулгыг тухай бүр холбогдох дээд байгууллагад хүргүүлэн ажилласан.

Бүгд Найрамдах Турк Улсын Ерөнхий сайд Бинали Йылдырым, Холбооны бүгд найрамдах Герман улсын батлан хамаалахын сайд У.Фон Дер Лайен, Оросын Холбооны Улсын Батлан хамгаалахын сайд С.К.Шойгу зэрэг Төрийн болон гадаад орны өндөр, дээд хэмжээний зочин төлөөлөгчдийн Монгол Улсад албан ёсны айлчлал хийх үеэр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хамгаалалтын төлөвлөгөөний дагуу Хамгаалалтын салбар төлөвлөгөөг гаргаж, хэлтсийн нийт бие бүрэлдэхүүнд танилцуулан, хэлтсийн дарга болон Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга нэгдсэн үүрэг чиглэл, зааварчилгаа өгч, алба хаагч нэг бүрээр гарын үсэг зуруулан хувцас форм, тусгай хэрэгсэл, гэрэл ойлгогчтой хантааз, агсамжинд үзлэг шалгалт хийж, алба хаагч бүрийн хувийн бэлтгэлийг хангуулан, хамгаалалтын үед үүсч болзошгүй гэмт хэрэг, зөрчлийг баримтжуулах дүрс бичлэгийн камер, фото аппарат, нөөц батарей, хэргийн газрын хамгаалалтын тууз, олс бэлтгэн албаны бэлэн байдлыг хангаж, 160 алба хаагч ажилласан.

2.2 Урьдчилэн сэргийлэх чиглэлээр

Хөршийн хяналтын бүлэг болон нийтийн эргүүлээс ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авч, холбогдох байгууллагад мэдээлэх, хүргэх, шийдвэрлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажилласан. Мөн “Хөршийн хяналтын бүлэг”-ийн үйл ажиллагаандаа ашиглах гарын авлага, аргачилсан зөвлөмж танилцуулан, нутаг дэвсгэрийн суурьшлийн бүсийн онцлогт тохируулан орон сууцны орц, гудамжаараа сайн дураараа нэгдэн хөршийн хяналтын бүлэг байгуулах үйл ажиллагааг дэмжих, хөршийн хяналтын бүлгийн гишүүдийг чадавхижуулах, үйл ажиллагааг нь эрчимжүүлэх чиглэлээр хэсгийн ахлагч 20, урамшилт эргүүлийн 19 иргэн иргэдтэй хамтран эргүүлийн үүрэг гүйцэтгэсэн.

Тус хэлтсээс Иргэний зөвлөлтэй хамтран “Цагдаа, иргэний холбоо” сэдэвт уулзалтыг зохион байгуулж, хорооны Засаг дарга, нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч, оршин суугч иргэд нийт 65 хүн хамрагдсан. Уулзалтаар камерын хяналтыг сайжруулах зорилгоор стандартад нийцсэн камерын тоог нэмэгдүүлэх, урамшилт эргүүлийг үр дүнтэй ажиллуулах, хөршийн хяналтын бүлэг болон иргэдийг хамруулсан нэгдсэн эргүүлийг зохион байгуулах, эргүүлийн хүн хүчийг нэмэгдүүлэх зэрэг саналыг удирдах дээд байгууллагад уламжилахаар шийдвэрлэсэн.

Хариуцсан хорооны нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 20 иргэн 20 чиглэлд хэв журмын урамшилт эргүүлээр үүрэг гүйцэтгэх хугацаандаа 16 санамж, сэрэмжлүүлэг тарааж, цагдаагийн 102 тусгай утсанд дуудлага 2 удаа өгч, олон нийтийн газар танхайрч байсан 2 иргэнийг машинт эргүүлийн алба хаагч нарт хүлээлгэн өгч ажилласан. Хариуцсан нутаг дэвсгэрийн ерөнхий боловсролын 8 хорооны нутаг дэвсгэрт байрлах 20 сургуулийн “School police”-ийн үйл ажиллагааг шалгаж, зааварчилгаа өгч ажилласан.

Тус хэлтсээс дүүргийн Прокурорын газартай хамтран хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд захиргааны хяналтанд байгаа 136 ялтнуудад хууль, эрх зүйн мэдлэг олгох сургалтыг 2 удаа зохион байгуулж, дахин гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй байх баталгаа авсан. Захиргааны хяналтын материалын бүрдлийг хангуулан дүүргийн Прокурорын газарт захиргааны хяналтанд байгаа ялтнуудын хувийн хэргийг бүрдлийг Улсын ерөнхий прокурор, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/05, А/09 дугаар тушаалаар батлагдсан “Тэнсэгдсэн ялтанд хяналт тавих журам”-ын дагуу хангуулж, 9 удаа зөрчил дутагдалгүй хянуулж ажилласан.

Тус хэлтсээс 2018 онд аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдэд гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар мөрдөгч нараас нийт 301 албан мэдэгдэл өгч, 270

хариу, хэсгийн байцаагч нараас 1179 шаардлага өгч, 790 хариуг авч, 680 шаардлагын биелэлтийг газар дээр нь үзэж, үр дүнг нь тооцож ажилласан.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх салбар төлөвлөгөөг гарган хэлтсийн даргаар батлуулан биелэлтийг гарган Нийслэлийн цагдаагийн газарт хүргүүлсэн. Тус хэлтсээс "Нарантуул" олон улсын худалдааны төвийн Хяналт зохион байгуулалтын алба, Эрүүл ахуйн албатай хамтран Баянзүрх дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах "Нарантуул" олон улсын худалдааны төвийн эртний эдлэл, малчдад зориулсан эд зүйл худалдан борлуулдаг хэсэгт хавх, агнахыг хуулиар хориглосон амьтны арьс, өд зэргийг худалдан борлуулж байгаа эсэхэд үзлэг, шалгалтыг хийхэд ямар нэгэн зөрчил дутагдал илрээгүй.

Байгууллагын үйл ажиллагаа, ажил үйлчилгээний талаар телевиз, радио, өдөр тутмын сонинд 38 мэдээ, мэдээлэл, 12 удаа ярилцлага өгч, 2 удаа нэвтрүүлэгт оролцсон. Мөн тус цагдаагийн хэлтсийн хэлтсийн "*bayanzurkh-1.police.gov.mn*" цахим, "Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн нэгдүгээр хэлтэс" нэртэй фейсбүүкийн пэйж хуудсанд хэлтсийн үйл ажиллагааны нийт 250 мэдээллийг байршуулан ажилласан.

2.3 Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр

Улсын баяр наадмаар хүүхдийг эцэг, эхээсээ төөрөх, гэмт эхрэг, зөрчилд өртөж хохирох, холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор хүүхдүүдийн гаранд утасны дугаартай бугуйвч 380 ширхэгийг тараасан, сургуулийн орчмын замын гарцын хажууд хүүхдийг зам тээврийн ослоос хамгаалах зориулалт бүхий дүрэмт хувцастай хүүхдийн маниканыг байрлуулсан. Өсвөрийн цагдаа нараар харьяа сургуулийн хичээлийн завсарлагаанаао хүүхдүүдэд хүүхдүүдээр нь шаардлага тавиулах чиглэлээр ажил арга хэмжээг зохино байгуулсан. Ерөнхий боловсролын сургуулиудын эцэг, эхийн зөвлөлтэй байршил тогтоогч төхөөрөмжийн үнийн судалгааг гаргаж, 2019 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн ажилласан.

Баянзүрх дүүргээс 2018 оныг "Хүүхдийн хөгжлийн жил" болгон зарласантай холбогдуулан Баянзүрх дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн төвтэй хамтран "Илрүүлэлт", "Тэнэмэл", "Хараа хяналт" зэрэг хэсэгчилсэн арга хэмжээ, 2 аяныг зохион байгуулан ажилласан. Тус хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрт байрлах зах худалдааны төв, зам дээр ундаа, мөхөөлдөс зардаг 22 хүүхдийг бүртгэлжүүлэн тэдний эцэг, эхэд хууль, эрх зүйн зөвлөгөөг өгч ажилласан.

Тус хэлтсээс 150 хүүхдийг Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборт хүлээлгэн өгч, бүртгэл судалгаанд тухай бүр баяжилтийг хийж ажилласан. Тус хэлтсээс хүүхэд гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй эмзэг 54 цэгийн судалгааг зургийн хамт гаргаж Нийслэлийн цагдаагийн газрын хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэст хүргүүлсэн.

Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгийн газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн хоёр, гуравдугаар хэлтэстэй хамтран "Хүүхэд хамгаалал-Миний оролцоо" сэдэвт Хүүхдийн III чуулганыг зохион байгуулж, дүүргийн нутаг дэвсгэрт оршин суудаг, сурч боловсорч буй 200 гаруй хүүхдийн төлөөлөл оролцсон зөвлөгөөний зохион байгуулсан. Зөвлөгөөнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх, Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга, Баянзүрх дүүргийн Засаг дарга болон харьяа газар, хэлтсийн 160 гаруй ажилтан, алба хаагчид, 200 гаруй оюутан, сурагчдын төлөөлөл урлаг, соёлын алдартнууд "Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг нэгдэж, Хүмүүжлийн эерэг аргыг хэвшүүлье, Таны оролцоо-Таны гарын үсэг уриалгыг дэмжиж буйгаа идлэрхийлэн 400 гаруй хүн гарын үсэг зурсан.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг гар утас, үнэт эд зүйл хэрэглэхгүй байх талаар сурталчлахаар сургалтын хуваарь гаргаж, хэлтсийн даргаар батлуулан

хариуцсан хороодын 10 сургуульд хэсгийн байцаагч нарын хамт сургалт зохион байгуулан ажилласан. Энэ чиглэлээр 3 төрлийн зурагт хуудас 200 ширхэг, санамж, сэрэмжлүүлэг 80 ширхэгийг тараасан.

Баянзүрх дүүргийн Боловсролын хэлтэстэй хамтарч Цагдаагийн нэг, хоёрдугаар хэлтэс болон замын цагдаагийн хэлтэстэй хамтран “Хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо” сэдэвт зөвлөгөөн зохион байгуулсан. Уг зөвлөгөөнд 500 хүн оролцсон. Арга хэмжээг ЕТВ телевизээр иргэдэд мэдээлсэн.

“Дэвжээ-2018” тэмцээнийг Хууль сахиулах их сургуулийн Цагдаагийн сургууль, Дүүргийн Боловсролын хэлтэс, Цагдаагийн хоёр, гуравдугаар хэлтэстэйгээ хамтран 14 ерөнхий боловсролын сургуулийн багш, нийгмийн ажилтан, эцэг эх, сурагчдын дунд зохион байгуулж ажилласан.

Хариуцсан нутаг дэвсгэрт байрлах 9 ерөнхий боловсролын сургуулиудын “School police”-ийн үйл ажиллагааг 4 удаа шалгаж, зааварчилгаа өгч ажилласан.

Тус хэлтэст 2018 оны эхний 11 сарын байдлаар хүүхэд оролцсон гэмт хэрэг 28 бүртгэгдсэн ба үүнээс хөнгөн хэрэг 21, хүнд хэрэг 7 байна. Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийг насны байдлаар нь авч үзвэл: 14-15 насны 16 хүүхэд, 16-18 насны 12 хүүхэд байна. Гэмт хэргийн улмаас нас барсан хүүхэд байхгүй байна. Мөн тус хэлтэст 18 хүүхэд оршин суугаа газраасаа сураггүй алга болсон гэж бүртгэгдсэнээс бүгд олдож эрэн сурвалжлалтыг зогсоосон.

2.4. Гэмт хэрэгтэй тэмцэх ажлын талаар

Тус хэлтэст 2018 оны эхний 11 сарын байдлаар иргэд аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлсэн нийт 7496 гомдол, мэдээлэл хүлээн авч, шийдвэрлэсний 4380 буюу 58,4 хувь нь гэмт хэргийн, 3116 буюу 41,5 хувь нь захиргааны зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг хэлтсийн нэгдсэн бүртгэлд бүртгэн, санд баяжилт хийн, хяналт тавьж ажилласан.

Гэмт хэргийн шинжтэй 4380 гомдол, мэдээллийн 2396 буюу 54,7 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, 1879 буюу 42,8 хувийг нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлж, 26 буюу 0,6 хувийг харъяаллын дагуу шилжүүлсэн. Зөрчлийн талаарх 3116 гомдол, мэдээллийн 1253 буюу 40,2 хувийг зөрчлийн хэрэг нээсэн, 1843 буюу 59,1 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан, 14 буюу 0,4 хувийг харъяаллын дагуу шилжүүлсэн.

2018 онд 2494 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 861 нэгжээр буюу 52,7 хувиар өссөн. Хэрэг бүртгэлтийн хэрэг 2451 хэрэг бүртгэгдсэн, үүнээс 554 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон.

Нийт хэргийн илрүүлэлт 22,6 хувьтай, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4 пунктээр буурсан. Хөнгөн хэргийн илрүүлэлт 23,6 хувьтай, 1,2 пунктээр буурсан, хүндхэргийн илрүүлэлт 16,9 хувьтай, 7 пунктээр буурсан,

Гудамж талбайд 663 хэрэг бүртгэгдэж 327 нэгжээр буюу 97,3 хувиар өссөн. Согтуугаар үйлдэгдсэн хэрэг 31 бүртгэгдэж 37 нэгжээр буюу 54,4 хувиар буурсан.

Тайлангийн хугацаанд нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт хэргийн талаар мэдээ, мэдээлэл цуглуулан 725 холбогдогчтой, 898,3 сая төгрөгийн хохиролтой 771 гэмт хэрэг, үйлдэл илрүүлэн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах алба болон бусад газар хэлтсүүдэд шилжүүлсэн байна.

Прокурорын байгууллагаас /ЭХХШТХ-ийн 41.2.1/ нийт 436 даалгавар хүлээн авч 436 даалгаварт заасан ажиллагааг хийж гүйцэтгэсэн. Алба хаагчдаас ЦБҮАЖ-ын код 307-д заасан "Илтгэх хуудас"-аар 506 мэдээ, мэдээлэл дэд санд авагдсанаас 128 мэдээллийг засуулахаар буцааж, 303 мэдээллийг эрүүгийн мөрдөгч нарт хуваарьлан шалгуулснаас 115 мэдээлэл батлагдсан, 188 шалгаж байна.

Тус хэлтэст шалгасан хэргийн улмаас 2480 иргэн, аж ахуй нэгж, байгууллагад 12,595,7 сая төгрөгийн хохирол учирснаас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд 1,796,6 сая төгрөгийг нөхөн төлүүлж, шүүхээс эд хөрөнгө хураах, иргэний нэхэмжлэлийг

хангах зорилгоор холбогдчон этгээдийн гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан болон хувьд ногдох 367,0 сая төгрөгийн эд хөрөнгийг битүүмжилсэн.

Алба хаагчдаас 2018 оны эхний 11 сарын байдлаар 11 прокурорын шаардлага ирснийг бүртгэн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 246 дугаар тушаалаар батлагдсан цагдаагийн байгууллаган үйл ажиллагааны журам “Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах /код-112/”-ын дагуу албан шалгалт явуулж, шалтгаан нөхцөлийг тодруулан хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хариуг бичгээр өгөх ажил хэвшил болсон. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаалтын чиглэлээр зөрчил дутагдлыг арилгуулахаар ирүүлсэн прокурорын шаардлагуудын шалтгаан нөхцөлийг судлан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах эрх бүхий алба хаагчдад 11 удаа 12 цагийн сургалтанд давхардсан тоогоор давхардсан тоогоор 308 алба хаагчид сургалт орж, бичгээр зааварчилгаа өгч, үр дүнг тооцон ажилласан. Мөн дүүргийн прокурорын газартай хамтран 5 удаагийн зөвлөгөөн зохион байгуулсан. Зөвлөгөөнийг хяналтын прокурор, хэлтсийн дарга, тасгийн дарга, алба хаагч нарыг оролцуулан гаргасан алдаа, дутагдлыг дүгнэсэн, цаашид хэрхэн хамтран ажиллах талаар сонсгол хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах АСАП санд эрэн сурвалжлагдаж байсан гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 401 зарлагдсанаас 355, 25 оргодол этгээдээс 20, эрэн сурвалжагдаж байсан эд зүйл 1457 зарлагдсанаас 956 олж тогтоон шийдвэрлэж, сангийн зөрчлийг арилгах хасалт хийлгэх талаар ЭЦА-ны 7 дугаар хэлтэст танилцуулгыг хүргүүлэн ажилласан. Эрэн сурвалжлах АСАП сангийн ашиглалт бүрдүүлэлтийг хангах чиглэлээр 2018 оны 08 дугаар сарын 06-ны өдөр бүх тасгуудад №02 үүргийг хүргүүлэн хэлтсийн алба хаагч нэг бүрийг АСАП санд эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйлтэй танилцах, мөн санд зөрчилтэй зарлагдсан хүн, эд зүйлийн тулгалт хийх, шийдвэрлэгдсэн, олдсон сэрдэгдсэн этгээд, хүн, эд зүйлийг санд зогсоох чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажилласан.

Тус хэлтсээс 2018 онд эрүү, хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, гэмт хэрэг, зөрчлийг бууруулах чиглэлээр 23 нэгдсэн болон хэсэгчилэн арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцоход халаасны хулгайн гэмт хэрэг үйлддэг 13, иргэдийн өмчийн хулгай, дээрмийн гэмт хэрэг үйлддэг 41, орон нутаг дамжин тэнэдэг архаг архичин этгээдүүд 54, бусад сонирхол татсан ченжүүд зэрэг нийт 277 этгээдийг судалгаанд авсан, орон гэргүй тэнэмэл байдлаар амьдардаг нийт 60 иргэнээс 49 иргэнийг бүртгэлжүүлж, архины хамаарал их 29 иргэнийг дүүргийн эмнэлэгийн үзлэгт хамруулсан, халаасны хулгайн 15 гэмт хэрэг илрүүлэн, 16 хүнийг бүртгэл судалгаанд авсан, халаасны хулгайн гэмт хэрэг үйлдэгддэг газруудад зурагт самбар байршуулан, иргэдэд сэрэмжлүүлэг, зөвлөмж хэвлэмэл хуудас 800 ширхэг тараасан, гэмт хэргийн замаар олсон эд зүйлсийг худалдан авч зарж борлуулдаг олсон орлогоо амьдралын эх үүсвэрээ болгосон хуучин хэрэглэж байсан эд зүйл зардаг ченж 87, сум, алт, мөнгөн эдлэл авч зарж борлуулдаг ченж 73, цахилгаан бараа зурагт авч зарж борлуулдаг ченж 9 зэргийн судалгааг баяжуулсан, гэмт хэрэг үйлдээд оргон зайлсан оргодол, сэрдэгдсэн 42 этгээдийг олж тогтоон холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгсөн, 14 барьцаалан зээлдүүлэх газрыг шалган, хулгайн гэмт хэрэг үйлдэж болзошгүй сэжигтэй этгээд 14 шинээр бүртгэл судалгаанд авч 31 хэргийг илрүүлэн мөрдөн байцаах тасагт шилжүүлсэн, гэмт хэрэг үйлддэг, гэмт хэрэг үйлдэж болзошгүй сэжигтэй, орон гэргүй тэнэмэл байдлаар амьдардаг, архи ууж хог түүж явдаг нийт 194 этгээдийн зураг бүхий дэлгэрэнгүй судалгааг хийж, 194 гарын дардасыг ШШҮХ-ийн Криминалистикын шинжилгээний үндэсний төвд гарын мөрний “Папилон” санд оруулуулахаар хүргүүлсэн, хоёрдогч түүхий эд авдаг 10 цэг, “Өгөөмөр” техникийн зах дээр аккумулятор зарж борлуулдаг 26 иргэний дэлгэрэнгүй судалгааг шинэчлэн гаргаж, дээрх иргэн аж ахуйн нэгжүүдэд гарал үүсэл тодорхойгүй аккумулятор болон эд зүйл худалдан авахгүй байх

талаар албан мэдэгдэл хүргүүлэн, гарал үүсэл тодорхойгүй зай хураагууруудыг тогтоон гарал үүслийг шалгах, албан мэдэгдэлийн хариуг авсан, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, иргэдийн судалгааг шинэчлэн гаргасан, хариуцсан нутаг дэвсгэрт үйлдэгдсэн 69 хэргийн судалгааг гарган, 29 хэрэгт зааварчилгаа бичгээр өгч, 8 хэргийг илрүүлэн яллагдагчаар татахаар прокурорт шилжүүлсэн, хариуцсан нутаг дэвсгэрт зохих зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа дэн болон зочид буудлуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, 3 зөрчлийг илрүүлэн Зөрчлийн тухай хуулийн 10.4.1-д заасны дагуу шийтгэлийн хуудсаар тус бүр 500,000 төгрөгөөр торгосон, архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгж, дэн буудал зочид буудал, саун массажны газар, цахим тоглоомын газар, түргэн үйлчилгээний цэгийн цагийн хуваарьт хяналт тавьж 35 аж ахуйн нэгжид шийтгэлийн хуудсаар 5,125,0000 төгрөгөөр торгосон, гэрээт харуул хамгаалалтын 8 албаны захирал ажилтан нартай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, талаар яриа таниулга хийж, гэмт хэрэг ихээр үйлдэгдсэн хорооны нутаг дэвсгэр цагдаагийн 6 алба хаагч гэрээт хамгаалалтын 12 алба хаагчтай хамтран 8 чиглэлд эргүүлийн үүрэг гүйцэтгэн ажиллахад эргүүлийн чиглэлд гэмт хэрэг, зөрчил бүртгэгдээгүй. Мөн нийт 12 удаагийн үйлдэл 14 ширхэг унадаг дугуй хулгайлдагдсан гэмт хэргийг илрүүлсэн, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарч хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 удаа нийт 160 гаруй хүүхдүүдэд хууль, эрх зүйн чиглэлээр яриа таниулга хийж, 13, 14, 19, 22, 24 дүгээр хороодын нийгмийн ажилтан нартай хамтран гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй 32 айл өрхөөр орж эрсдэлийн үнэлгээ хийж судалгаанд авч, 3 төрлийн анхааруулга бүхий зурагт хуудас 400 ширхэгийг хариуцсан 8 хороодын аж ахуйн нэгж, байгууллага, автобусны буудал, таксины зогсоол, архи согтууруулах ундаагаар үйлчилдэг цэгүүдэд болон аж ахуй нэгж, байгууллагын мэдээллийн самбарт байршуулан иргэд, байгууллагад хүргэж ажилласан байна.

Мөрдөн байцаалтын чиглэлээр: Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй 1423, мэдээлэл хүлээн авч шалгаж 701 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 637 гомдол мэдээлэлд хэрэг нээхээс татгалзах саналтай прокурорт шилжүүлсэн ба харъяаллын дагуу 23 гомдол, мэдээлэл шилжүүлж 62 гомдол мэдээлэл шийдвэрлээгүй үлдэгдэлтэй байна.

Тайлангийн хугацаанд 1641 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулан 356 холбогдогчтой 334 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорын хяналтанд шилжүүлж, 677 хэргийг хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын хэргийг хаах саналтай прокурорт шилжүүлж, 65 хэргийг нэгтгэн, 123 хэргийг бусад газарт харъяаллын дагуу шилжүүлж одоо 442 хэргийн үлдэгдэлтэй байгаагаас хэрэг бүртгэлтийн 384, мөрдөн байцаалтын 58 хэрэг байна.

Сар тутамд шийдвэрлэх хэргийн график гарган Дүүргийн прокурор болон Мөрдөн байцаах албаны даргаар батлуулж, хугацаа сунгасан болон прокурор, шүүхээс нэмэлт мөрдөн байцаалтанд буцсан хэргийг графикт оруулан нийт 212 хэргийг шийдвэрлүүлсэн.

Цагдан хоригдсон давхардсан тоогоор 78 яллагдагчидтай тасгийн дарга 21 хоног тутам биечлэн уулзаж санал хүсэлтийг нь авсан.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын эрхийг хангах зорилгоор хохирогч, гэрч, яллагдагч, тэдгээрийн өмгөөлөгчөөс бичгээр гаргасан 70 хүсэлтийг хүлээн авч тасгийн нэгдсэн бүртгэлд бүртгэн, хуульд заасан хугацаанд хариуг өгч шийдвэрлэсэн.

Шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн 334 хэргийн 286 хэрэгт гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгаан нөхцөлийг арилгахаар мөрдөгчийн мэдэгдэл бичиж хариу хуулийн хугацаанд авч зарим мэдэгдлийн мөрөөр хийсэн ажиллагааг газар дээр нь шалгах ажиллагааг нэгдсэн байдлаар дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх

зөвлөлийн гаргасан төлөвлөгөөний дагуу хийхээр ажиллаж байгаа бөгөөд мэдэгдлийн тоо хангалтгүй байгаад анхаарч тасгийн даргын зүгээс мэдэгдэл 100 хувь бичиж хариу авах ажлыг ахлах мөрдөгч нарт хариуцуулан ажиллаж байна.

2018 онд гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид нийт 11,660,106,230 төгрөгийн хохирол учирснаас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд 3,776,455,540 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн мэдээ өгч, хохирол нөхөн төлүүлэх, эд хөрөнгө битүүмжлэх, хөрөнгө хурааж болзошгүй байдлыг хангах зорилгоор 16 сая төгрөгний эд хөрөнгө битүүмжлэн мэдээг мөрдөгчид санд оруулсан нь учирсан хохирлын 36,3 хувийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн.

Хэрэг бүртгэлтийн чиглэлээр: Иргэд аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлсэн гэмт хэрэг шинжтэй 669 гомдол, мэдээлэл, хүлээн авч, 430 гомдолд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 233 гомдлыг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах санал гаргаж, 1 гомдол мэдээллийг харъяаллын дагуу бусад газарт шилжүүлж 5 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй байна. Нийт гомдлын шийдвэрлэлт 100 хувьтай, хүлээн авч шалгасан гомдлын 64.2 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 34.8 хувийг татгалзах санал гаргаж шийдвэрлэсэн.

Тайлангийн хугацаанд шинээр зөрчлийн 134 хэргийг нээж, урьд оны үлдэгдэл 39, нийт 173 хэрэгт зөрчил шалгах ажиллагаа явуулснаас 19 хэргийг буюу 10,9 хувийг шүүхээр шийтгэл ногдуулахаар прокурорт, 20 хэргийг буюу 11,5 хувийг харъяаллаар шилжүүлж, 8 хэргийг буюу 4,6 хувийг хэрэгсэхгүй болгож, 16 хэрэгт буюу 9,2 хувийг албадлагын арга хэмжээ авхуулж, 97 хэрэг буюу 43 хувийн үлдэгдэлтэй ажиллагаанд шалгагдаж байна.

Зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулах, дахин гэмт хэрэг, зөрчил гаргуулахгүй байх зорилгоор Зөрчлийн тухай хуулийн 5.9 дүгээр зүйлийн 1.3 заасны дагуу хэрэг бүртгэгчийн мэдэгдэл 8-ийг хүргүүлж, 7 удаа хариуг авч биелэлтийг тооцсон.

Хэрэг бүргэх тасаг нь 2018 оны 02 дугаар сарын 01-ны өдрөөс Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Эрх олгох тухай” А/45 дугаартай тушаал, Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2018 оны Б/35 дугаартай тушаал, Цагдаагийн Ерөнхий газрын тэргүүн дэд даргын 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 2/48 дугаартай ажлын чиглэл, Хэрэг бүртгэх албаны даргын 2018 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн үүрэг, ажлын чиглэлийн дагуу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11 дүгээр бүлэгт заасан гэмт хэргийг Хэрэг бүртгэх тасаг нь шалгах болсонтой холбогдуулан Нийтийн хэв журам хамгаалах тасагт Зөрчлийн тухай хуульд заасан зүйл ангиар нээсэн 170 хэрэг, зөрчлийн шинжтэй 3 гомдол мэдээллийг хүлээлгэн өгч Эрүүгийн цагдаагийн тасгаас 104, мөрдөн байцаах тасгаас 108 нийт 212 эрүүгийн хэргийг хүлээн авч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байна. Хүлээн авсан нийт хэргийг зүйл ангиар нь авч үзвэл эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.1 дүгээр зүйлд заасан 18, 11.3 дугаар зүйлд заасан 1, 11.4 дүгээр зүйлд заасан 21, 11.6 дугаар зүйлд заасан 172 хэрэг байна.

Долоо. Дүгнэлт

Тайлант хугацаанд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, илрүүлэх чиглэлээр 22 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулж, 71 удаагийн нэгдсэн үзлэг шалгалтад гарч ажилласан ба 141 удаа сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажил зохион байгуулж, 10 удаагийн өдөрлөг зохион байгуулж, нийт 244 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 18870 иргэнийг хамруулж ажилласнаар согтуугаар үйлдсэн гэмт хэргийн гаралт 54,4, зөрчлийн хэрэг 47 хувиар буурч, иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг дээшилсэн.

Цагдаагийн ерөнхий газрын удирдлага, тэргүүн дэд дарга, дэд дарга нараас алба хаагчдын сахилга, ажлын хариуцлагыг сайжруулах чиглэлээр ирүүлсэн 2017 оны 01 тоот албан даалгавар, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 01/591, Тэргүүн дэд даргын 2017 оны 5/27, 5/362, 5/393, 2018 оны 5/270, Нийслэлийн цагдаагийн газрын 2017 оны 14а/6077, 14а/6128, 14/6139 тоот албан бичгээр ирүүлсэн ажлын чиглэл,

үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тус бүрт төлөвлөгөө гарган, биелэлтэд хяналт тавин ажиллаж, ажлын чиглэл, үүргийг хэрэгжүүлэх, зөрчихгүй байх талаар 8 заалт бүхий баталгааг 170 алба хаагчаас бичгээр гаргуулан авч, сахилга, хариуцлагын зөвлөгөөнийг 3 удаа зохион байгуулсан.

Алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд давхардсан тоогоор 209 алба хаагчийг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд үнэгүй хамруулж, 10 алба хаагчид өмчлөлийн газар олгуулахаар асуудлыг хүргүүлж, ажиллах урам зоригийг сэргээх, стресс ядаргааг тайлах зорилгоор соён гэгээрүүлэх ажлыг 30 удаа давхардсан тоогоор 3621 алба хаагчийг хамруулж, давхардсан тоогоор 149 алба хаагчийн албан тушаалын цалинг 5-40 хувь нэмж алба хаагчдын ажиллах урам зориг нэмэгдсэн.

Найм. Цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг дарагдуулалгүй бүртгэлд оруулж, дуудлага, мэдээллийн дагуу шуурхай очиж, хойшлуулшгүй ажиллагааг бүрэн дүүрэн, шуурхай хийж хэргийг халуун мөрөөр нь илрүүлэхэд багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, бэхжүүлэх

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад тасгийн дарга, ахлах нараас тавих хяналт, алба хаагчидтай ажиллах ажиллагааг сайжруулж, хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын ажиллагааг шуурхай бүрэн дүүрэн, процессын зөрчилгүй явуулах

Шинэчлэгдэн батлагдсан хуулиудыг хэрэглэх ур чадварыг нэмэгдүүлэх, эрх бүхий алба хаагчдыг дадлагажуулах, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах.

БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ ДЭХ
ЦАГДААГИЙН НЭГДҮГЭЭР ХЭЛТЭС